

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/17/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn Аудитор: М.Ганбаатар Утас: 261628 Цахим хаяг: ganbaatar@audit.gov.mn Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.АМАРСАНАА ТАНАА

2024. 02. 23 № 07/288

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын зээлийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 176,659,468.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1, 76 дугаар зүйлийн 76.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын зээлийн сан нь төвлөрсөн төсөвт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн 1993 онд Шинжлэх ухаан, боловсролын яамны дэргэд “Сургалтын төрийн сан” нэртэйгээр анх байгуулагдаж, тайлант онд байгууллагын 30 жилийн түүхт ой тохиосон байна. Үүсэн байгуулагдсан цагаасаа сурах хүсэл эрмэлзэлтэй, гадаад дотоодын их дээд сургуульд элсэх шалгуур хангасан боловч сургалтын төлбөрийн дэмжлэг шаардлагатай суралцагчдад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Өндөр хөгжилтэй оронд бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцсан нийт 462 суралцагчийн 12,635,722.97 ам.долларын зээлийн, 159 суралцагчийн 2,941,237.9

ам.долларын хүүгийн авлагын, Дэлхийн шилдэг их сургуульд суралцсан 164 харилцагчийн 19,591,404.91 ам.долларын зээлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, найдваргүй болох эрсдэлтэй байна. Үүнээс гэрээний үүргээ биелүүлээгүй нийт 3,438,011.98 ам.долларын санхүүжилт авсан 147 зээлдэгчтэй холбоо тогтоогоогүй, зээлийн эргэн төлөлтийн график байгуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын хамрах хугацаанд Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан ажлын хэсгээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж, сангаас 1997-2023 оны санхүүгийн баримт материалыг эд мөрийн баримтаар хураан авч, шинжилгээнд хүргүүлсэн байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргах, давж заалдах хугацаа дуустал хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тусгай байранд хадгалж, энэ тухай баримтыг хавтаст хэрэгт хавсаргана” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны 2023 оны 8и-3/12308 дугаар бүхий албан бичгээр холбогдох баримт материалыг Үндэсний аудитын газарт хүргүүлэх боломжгүйг мэдэгдсэн тул аудитын баг Боловсролын зээлийн сангаас 2023 онд зээлээс чөлөөлсөн суралцагчдын анхан шатны баримтад аудит хийгдээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2024\0223 SNAG-34.Docx



Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	308,307,328,337.03	301,013,315,675.57
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,060,178.99	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,060,178.99	-
31220	Гадаад валют	1,060,178.99	-
31222	Монгол банк дахь харилцах	1,060,178.99	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	305,900,596.37	144,465,837.58
32100	Үнэт цаас	305,900,596.37	144,465,837.58
32110	Төгрөг	305,900,596.37	144,465,837.58
33	АВЛАГА	274,061,473,489.41	257,856,401,312.98
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	244,138.47	1,342,922.39
33400	Зээлийн хүүгийн авлага	485,390.32	221,125.30
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	-	66,000.00
33500	Бусад авлага	96,005,361.85	66,125,433.85
33510	Байгууллагаас авах авлага	96,005,361.85	66,125,433.85
33600	Зээлийн авлага	273,964,738,598.77	257,788,645,831.44
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	273,964,738,598.77	257,788,645,831.44
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	273,964,738,598.77	257,788,645,831.44
34	УРЬДЧИЛГАА	33,926,894,072.26	43,012,448,525.01
34600	Урьдчилж гарсан зардал	33,926,894,072.26	43,012,448,525.01
35	БАРАА МАТЕРИАЛ	12,000,000.00	-
35400	Хангамжийн материал	12,000,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	12,000,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	181,323,745.62	191,750,781.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	181,323,745.62	191,750,781.02
39200	Биет хөрөнгө	49,954,878.99	81,009,934.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,000,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,000,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	97,012,045.00	145,589,885.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(59,350,170.94)	(78,787,968.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,179,672.00	36,322,072.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,886,667.07)	(22,114,053.99)
39300	Биет бус хөрөнгө	131,368,866.63	110,740,846.59
39301	Програм хангамж	206,280,200.00	206,280,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(74,911,333.37)	(95,539,353.41)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	308,488,652,082.65	301,205,066,456.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,353,034.94	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,353,034.94	-
41300	Өглөг	4,353,034.94	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,309,734.94	-
41360	Бусад өглөг	43,300.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	43,300.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	308,484,299,047.71	301,205,066,456.59
51	Засгийн газрын хувь оролцоо	308,484,299,047.71	301,205,066,456.59
51100	Засгийн газрын оруулсан капитал	29,809,531.00	29,809,531.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	29,809,531.00	29,809,531.00
51200	Хуримтлагдсан үр дүн	308,454,489,516.71	301,175,256,925.59
51210	Өмнөх үеийн үр дүн	291,640,289,701.00	297,381,734,360.23
51220	Тайлант үеийн үр дүн	16,814,199,815.71	3,793,522,565.36

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	308,488,652,082.65	301,205,066,456.59
---	--	---------------------------	---------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	60,241,358,858.54	70,275,394,077.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	443,802,054.81	1,754,286,873.01
120	Нийтлэг татварын бус орлого	443,802,054.81	1,754,286,873.01
120002	Хүүгийн орлого	7,943,316.92	3,985,994.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	421,549,838.89	1,750,300,878.88
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	421,549,838.89	1,750,300,878.88
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	14,308,899.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	59,797,556,803.73	68,521,107,204.32
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	59,797,556,803.73	68,521,107,204.32
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	59,797,556,803.73	68,521,107,204.32
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	43,640,363,256.44	66,170,934,525.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,640,363,256.44	66,170,934,525.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	766,482,006.56	1,100,677,403.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,258,541.61	646,400,055.44
210101	Үндсэн цалин	296,779,427.23	396,059,354.40
210102	Нэмэгдэл	84,191,637.55	135,118,298.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,418,000.00	63,140,000.00
210104	Урамшуулал	45,869,476.83	52,082,402.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,960,350.95	83,269,983.03
210201	Тэтгэврийн даатгал	41,817,716.56	57,363,928.39
210202	Тэтгэмжийн даатгал	4,919,731.41	6,748,697.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,808,104.99	5,183,357.92
210204	Ажилгүйдлийн даатгал	946,799.83	1,270,363.60
210205	Эрүүл мэндийн даатгал	9,467,998.16	12,703,635.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,371,772.00	215,130,785.00
210304	Байрны түрээс	105,371,772.00	215,130,785.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,548,252.68	22,394,563.65
210401	Бичиг хэрэг	9,260,050.00	8,290,000.00
210402	Тээвэр, шатахуун	930,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,974,272.68	12,244,563.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,383,930.00	1,860,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,254,500.00	1,722,200.00
210604	Урсгал засвар	1,254,500.00	1,722,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,959,800.00	88,466,611.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,304,000.00	55,442,111.72
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,655,800.00	33,024,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,128,789.32	43,293,204.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,128,789.32	43,293,204.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,873,881,249.88	65,070,257,121.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,287,390,879.32	52,288,480,707.01

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,287,095,879.32	52,252,913,289.01
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	30,287,418.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	295,000.00	280,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,586,490,370.56	12,781,776,414.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,279,919,238.66	12,777,516,155.82
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,290,448.03	4,260,259.15
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	6,296,280,683.87	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	16,600,995,602.10	4,104,459,551.91
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	229,686,943.34	368,712,858.19
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	209,333,943.34	368,712,858.19
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	20,353,000.00	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,482,729.73	679,649,844.74
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	16,482,729.73	83,973,110.71
230001	Эргэж төлөгдөх зээл	-	595,676,734.03
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	16,814,199,815.71	3,793,522,565.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	66,387,161,661.88	81,906,024,562.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	421,513,900.40	1,750,290,878.88
120	Нийтлэг татварын бус орлого	421,513,900.40	1,750,290,878.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	421,513,900.40	1,750,290,878.88
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	421,513,900.40	1,750,290,878.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,965,647,761.48	80,155,733,683.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	65,955,357,313.45	80,151,473,424.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	59,797,556,803.73	68,521,107,204.32
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	6,157,800,509.72	11,630,366,220.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,290,448.03	4,260,259.15
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,290,448.03	4,260,259.15
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,655,919,226.64	66,118,208,356.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,655,919,226.64	66,118,208,356.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	782,037,976.73	1,047,839,616.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,215,200.00	651,874,574.30
210101	Үндсэн цалин	297,038,896.71	402,045,326.92
210102	Нэмэгдэл	84,560,922.00	134,749,256.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,093,000.00	63,059,578.17
210104	Урамшуулал	44,522,381.29	52,020,412.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,857,110.45	83,269,983.03
210201	Тэтгэврийн даатгал	38,827,729.47	57,363,928.39
210202	Тэтгэмжийн даатгал	4,910,151.29	6,748,697.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,855,840.95	5,832,193.89
210204	Ажилгүйдлийн даатгал	872,567.95	1,270,363.60

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	9,390,820.79	12,054,799.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,251,700.00	212,068,383.33
210304	Байрны түрээс	135,251,700.00	212,068,383.33
2104	Хангамж, бараа материалын зардал	22,999,666.28	25,523,363.65
210401	Бичиг хэрэг	9,260,050.00	8,290,000.00
210402	Тээвэр, шатахуун	925,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,430,686.28	12,244,563.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,383,930.00	4,988,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,254,500.00	1,762,200.00
210604	Урсгал засвар	1,254,500.00	1,762,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,459,800.00	73,341,111.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,804,000.00	40,316,611.72
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,655,800.00	33,024,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,873,881,249.91	65,070,368,740.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,287,390,879.35	52,288,592,325.22
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,287,095,879.35	52,253,024,907.22
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	30,287,418.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	295,000.00	280,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,586,490,370.56	12,781,776,414.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,987,601,311.03	12,777,516,155.82
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,290,448.03	4,260,259.15
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	588,598,611.50	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,731,242,435.24	15,787,816,206.31
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,630,000.00	53,720,240.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,630,000.00	53,720,240.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,630,000.00	53,720,240.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,630,000.00	53,720,240.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(6,630,000.00)	(53,720,240.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(22,723,552,256.25)	(15,735,156,145.30)
14	Бусад эх үүсвэр	187,950,478.72	1,736,412.75
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	20,629,000.00	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	167,321,478.72	1,736,412.75
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	22,895,020,005.24	15,652,919,447.35
230001	Эргэж төлөгдөх зээл	22,895,020,005.24	15,652,919,447.35
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	16,482,729.73	83,973,110.70
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	16,482,729.73	83,973,110.70
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,060,178.99	(1,060,178.99)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,060,178.99
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,060,178.99	-

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	-	291,680,651,501.00	291,710,461,032.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(40,361,800.00)	(40,361,800.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	-	291,640,289,701.00	291,670,099,232.00
9	Тайлант үеийн үр дүн	-	-	16,814,199,815.71	16,814,199,815.71
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	-	308,454,489,516.71	308,484,299,047.71
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(11,072,755,156.48)	(11,072,755,156.48)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	-	297,381,734,360.23	297,411,543,891.23
19	Тайлант үеийн үр дүн	-	-	3,793,522,565.36	3,793,522,565.36
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	-	301,175,256,925.59	301,205,066,456.59

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,985,874,700.00	60,182,586,055.32	1,803,288,644.68	97.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,165,613,000.00	53,402,302,467.99	6,763,310,532.01	88.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,109,074,400.00	1,101,559,856.03	7,514,543.97	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	651,908,200.00	651,874,574.30	33,625.70	100.0
210101	Үндсэн цалин	406,239,400.00	402,045,326.92	4,194,073.08	99.0
210102	Нэмэгдэл	133,337,200.00	134,749,256.89	(1,412,056.89)	101.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,299,600.00	63,059,578.17	(1,759,978.17)	102.9
210104	Урамшуулал	51,032,000.00	52,020,412.32	(988,412.32)	101.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,140,500.00	83,269,983.03	870,516.97	99.0
210201	Тэтгэврийн даатгал	58,906,900.00	57,363,928.39	1,542,971.61	97.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,308,500.00	6,748,697.59	(440,197.59)	107.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,046,700.00	5,832,193.89	(785,493.89)	115.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,261,500.00	1,270,363.60	(8,863.60)	100.7
210205	Эрүүл мэндийн даатгал	12,616,900.00	12,054,799.56	562,100.44	95.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,726,500.00	212,068,383.33	658,116.67	99.7
210304	Байрны түрээс	212,726,500.00	212,068,383.33	658,116.67	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал	26,969,800.00	25,523,363.65	1,446,436.35	94.6
210401	Бичиг хэрэг	8,290,000.00	8,290,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,691,000.00	12,244,563.65	1,446,436.35	89.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,988,800.00	4,988,800.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,848,900.00	54,822,440.00	26,460.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	53,086,500.00	53,060,240.00	26,260.00	100.0
210604	Урсгал засвар	1,762,400.00	1,762,200.00	200.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,480,500.00	74,001,111.72	4,479,388.28	94.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,388,900.00	40,316,611.72	72,288.28	99.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,091,600.00	33,684,500.00	4,407,100.00	88.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,056,538,600.00	52,300,742,611.96	6,755,795,988.04	88.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,056,538,600.00	52,300,742,611.96	6,755,795,988.04	88.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,020,167,100.00	52,265,175,193.96	6,754,991,906.04	88.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,082,200.00	30,287,418.00	794,782.00	97.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	289,300.00	280,000.00	9,300.00	96.8

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,820,261,700.00	6,780,283,587.33	(4,960,021,887.33)	372.5
230001	Эргэж төлөгдөх зээл	1,820,261,700.00	6,780,283,587.33	(4,960,021,887.33)	372.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,985,874,700.00	60,182,586,055.32	1,803,288,644.68	97.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	91,985,874,700.00	68,463,741,961.54	23,522,132,738.46	74.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	91,985,874,700.00	68,463,741,961.54	23,522,132,738.46	74.4
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	(30,000,000,000.00)	(8,281,155,906.22)	(21,718,844,093.78)	27.6
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(30,000,000,000.00)	(8,281,155,906.22)	(21,718,844,093.78)	27.6
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	65	65	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	32	32	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	31	31	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32	32	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	32	32	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,260,259.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,260,259.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,260,259.15
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		4,260,259.15
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		4,260,259.15
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,260,259.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,260,259.15
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,260,259.15

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитаар нийт 3,463,940.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд Улсын төсвийн санхүүжилтийг 114,730.5 мянган төгрөгөөр, Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх дүнг 3,349,210.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн	1	3,463,940.8			1	3,463,940.8	1	3,463,940.8				
Дүн	1	3,463,940.8			1	3,463,940.8	1	3,463,940.8				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгээр гадаад улсад суралцаж байгаа 176 суралцагч дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөр болон гадаадын их сургуулийн суурь хөтөлбөрт хоёуланд нь хамрагдаж тэтгэлэг авсан байна. Үүнд: /Польш 14, Герман 39, Франц 13, Хятад 80, Литва 1, Унгар 19, Чех 4, Энэтхэг 6 суралцагч/	1				1							
Лавлагааны системийг “Наргил шийдэл” ХХК-аар /2020 оны 312 тоот гэрээ/ хийлгэхээр гэрээ байгуулсан ба 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Гэрээт ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр дуусгахаар хугацаа сунгасан боловч систем, программыг эцсийн байдлаар хүлээж аваагүй, хугацаа хэтэрсэн байна	1				1							
Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/293 дугаар тушаалаар сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрээ байгуулан, сургалтын төлбөр шилжүүлэх эрхээ авсан 4 суралцагчийн 74,068.15 ам.долларын сургалтын төлбөрийг тайлант онд шилжүүлээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна.	1						1					
Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг авсан 486 суралцагчийн 20,040,494.4 мянган төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг авсан 100 оюутны 5,488,531.0 мянган төгрөг, Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадад суралцагчид олгох тэтгэлэг авсан 149 суралцагчийн 3,398,876.6 мянган төгрөгийн тэтгэлгийн гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байхад зардлаар /213205-Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал/ бүртгэсэн байна	1						1					
Дүн	8	101,721,608.6	1	98,283,596.7	5	3,438,011.9	2					

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 16 зөрчлөөс журам, мэдээллийн сан, төлөвлөгөө, гүйцэтгэл, сонгон шалгаруулалт, гэрээний хэрэгжилттэй холбоотой 9 зөрчилд албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, барьцааны зүйл, орлогын эх үүсвэр, дотоод хяналттай холбоотой зөрчилд 7 зөвлөмж өглөө.

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам", Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-д оюутны хөгжлийн зээлийн эрсдэлийн сангийн талаар нарийвчилсан зохицуулалтгүйгээс эрсдэлийн сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна	1		1			
Гэрээний үүргээ биелүүлээгүй, авлага үүсгэсэн төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, ажилласан жил, холбоо барих хаяг, утасны мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргуулан авах талаар гэрээ болон холбогдох журмуудад тусгасан зүйл, заалтгүй, мэдээллийн эзнээс гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох байгууллагуудаас тухайн хүний талаар мэдээллийг гаргуулан авах зөвшөөрлийг цаасан болон цахим хэлбэрээр авч баталгаажуулаагүй байна	1		1			
Олгосон гадаад зээл болон оюутны хөнгөлөлттэй зээл, дэд зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн сан, Сангийн яамны өрийн удирдлагын мэдээллийн санд бүртгүүлээгүй, зээл олгох шийдвэр гаргалтад зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах нөхцөлийг бүрдүүлээгүй байна	1		1			
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй байна	1		1			

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>Дэлхийн шилдэг 50-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах эрх авсан, сургалтын зээлийн хөтөлбөрт хамруулах иргэнийг сонгон шалгаруулалтад баримтлах ажлын удирдамжийн Тав. "Шалгаруулалтын үе шат: 2023 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд ярилцлагын шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулна", Зургаа. "Сонгон шалгаруулалтын үнэлгээний аргачлал: Хоёрдугаар шатны сонгон шалгаруулалт шалгуур үзүүлэлт ба үнэлгээ өгөх аргачлал", Долоо. "Комиссын үйл ажиллагаа: 9-д Ярилцлагыг баталсан хугацаанд танхимаар болон цахим хэлбэрээр хийх бөгөөд ярилцлагыг видео хэлбэрээр бүтэн бичлэг хийж, архивд хадгална", 10-д "Комиссын гишүүд ярилцлагад оролцогчдоос энэхүү удирдамжид заасан үнэлгээ өгөх аргачлалын хүрээнд ижил тооны асуулт асууж, хариулт авна" гэж тус тус заасан, олон нийтэд зар тавьсан боловч Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/258 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалаар журамд заасан суурь шаардлага хангасан иргэдийн суралцах чадварын ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж, өмнөх ажлын хэсгийн сонгон шалгаруулалтад оролцох иргэдээс авсан ярилцлагын шалгалтыг тооцолгүй Суралцах чадварын ерөнхий үнэлгээний шалгалт авч үр дүнгээр нь сонгон шалгаруулалт хийсэн байна.</p>	1		1			
<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/293 дугаар "Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" тушаалаар 50, А/474 дүгээр тушаалаар 6, А/475 дугаар тушаалаар 8, нийт 64 суралцагч шалгарснаас 60 суралцагч Дэлхийн шилдэг их сургуулийн 50-д багтсан их, дээд сургуулийн 50 болон түүнээс дээш хувийн сургалтын тэтгэлэг авсан баримтыг ирүүлээгүй, сонгон шалгаруулалтын шаардлагад нийцээгүй байна.</p>	1		1			
<p>Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн эхний 20-д багтаагүй New York University сургуулиас хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад ороогүй санхүү, эдийн засаг мэргэжлээр урилга авсан 2 суралцагчийг сонгон шалгаруулсан байна</p>	1		1			
<p>Сонгон шалгаруулалтад тэнцсэн 64 суралцагчийн нэг жилийн дундаж сургалтын төлбөр дунджаар 167.9 сая төгрөг, суралцах дөрвөн жилд нийт зээлийн хэмжээ дунджаар 671.6 сая төгрөг болох бөгөөд суралцагч сургуулиа гэрээний хугацаанд төгсөж эх орондоо ирж ажиллах ба 8 жилд багтаан зээлийг төлж барагдуулахаар гэрээ хийсэн байна. Энэ нь тухайн суралцагч сард ойролцоогоор 7,000.0 мянган төгрөгийг төлөхөөр байгаа нь Монгол Улсын цалингийн дунджаас хэт өндөр байгаа тул найдваргүй зээлдэгч болох эрсдэлтэй байна.</p>	1		1			
<p>Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь тайлант онд дээд шатны төсөв захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнүүлээгүй</p>	1		1			
<p>Сургалтын байгууллагад эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн зориулалтаар банк, санхүүгийн байгууллагаас зээл (хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох мөнгөн хөрөнгө) авахад хүүгийн хөнгөлөлт үзүүлэхээр журамд тусгасан боловч журам хүчин төгөлдөр болсноос хойш хэрэгжээгүй байна</p>	1				1	

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Оюутны хөнгөлөлттэй зээлийн барьцаанд авсан 13304 дипломыг ердийн модон шүүгээнд хадгалж байгаа нь бусад этгээдийн хууль бус халдлага, гэнэтийн аюулд устаж алга болох эрсдэлтэй байна. Мөн E-Mongolia цахим системээс боловсролын лавлагаа тодорхойлолт авдаг болсон өнөө цагт зээлдэгчийн диплом нь барьцааны үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон байна	1				1	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын онцлогийг /гэрээнд төлбөрийг ямар валютаар тусгах, эргэн төлөлт хийхэд аль ханшийг мөрдөх болон гадаад болон дотоод тэтгэлэг, буцалтгүй тусламжийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх г.м/ нарийн тусгаагүй, хэт ерөнхий байдлаар хийгдсэн, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зарим хууль, тогтоомжид нийцээгүй байна.	1				1	
Хуулиар олгосон орлогын эх үүсвэр бүрдүүлэх, нэмэлт орлого олох талаар ажил зохион байгуулаагүй нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Тусгай сан нь дараах нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ: 6.1.1.улсын төсвийн хөрөнгө; 6.1.2.хандив, тусламж; 6.1.3.тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого; 6.1.4.зээлийн хүүгийн орлого" гэж заасантай нийцээгүй байна.	1				1	
Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Комисс томилох тухай" А/75 дугаар тушаалаар Дэлхийн шилдэг их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн суралцах иргэдийн сонгон шалгаруулалтын зохион байгуулах комиссыг байгуулахдаа Төрийн бус байгууллагын төлөөлөл оруулаагүй байна	1				1	
Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2014 оны А/169/93 дугаар тушаалаар батлагдсан Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.7-д Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг "Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай" хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна гэж тусгасан боловч уг журмыг боловсруулж, батлуулаагүй байна.	1				1	
Архивын өрөө нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан стандартад нийцээгүй, цахим архив үүсгээгүй, байнга хадгалагдах баримтуудыг улсын төв архивд шилжүүлээгүй, баримт бичиг устаж алга болох эрсдэлтэй байна.	1				1	
Дүн	16		9		7	